



СЭЛЭНГЭ АЙМАГ  
ОРХОНТУУЛ СУМЫН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2017 оны 04 сарын 19 өдөр


Дугаар 22

Баянцогт

Г Ахуй үйлчилгээний хөгжлийг дэмжих  
сумын дэд хөтөлбөр батлах тухай

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017-2020 оны стратеги төлөвлөгөөний 4.1.1 дэх хэсэг, сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.4.15 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 5-р хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Ахуй үйлчилгээний хөгжлийг дэмжих сумын дэд хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.
2. Энэхүү хөтөлбөрийн биелэлтийг жил бүрийн эцэст сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлagnаж байхыг сумын Засаг дарга П.Батбаатарт үүрэг болгосугай.

ДАРГА   
M.ЦОГБАЯР

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017.04.19-ний  
өдрийн 5-р хуралдааны тоот тогтоолын хавсралт



## АХУЙ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ СУМЫН ДЭД ХӨТӨЛБӨР

### Нэг. Сумын ахуйн үйлчилгээний салбарын өнөөгийн байдал

Орхонуул сум нь нийт 3672 хүн ам, 1008 өрхтэй. Үүнээс суурин өрх нь 595, хөдөөд 407 өрх амьдардаг. Сумын хэмжээнд бүртгэлтэй ажилгүй 74 иргэн байгаагаас, гоо сайханч 2, гагнуурчин 4, гар утас засварчин 1, оёдолчин 3, тогооч нарийн боовчин 8 нийт 18 ахуй үйлчилгээний салбарт ажиллах боломжтой иргэд бүртгэлтэй байна. 2017 оны 1 дүгээр улирлын байдлаар 12 иргэн ахуй үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд үүнд 12 иргэн ажлын байраар хангагдаж байна.

Ахуй үйлчилгээний цэг салбаруудыг үйлчилгээ бүрээр нь авч узвэл:

№	Багийн нэр	Үс засах үйлчилгээ	Гоо заслын үйлчилгээ	Хувцас захиалга засварын үйлчилгээ	Халуун усны үйлчилгээ	Гар утас засварын үйлчилгээ	Дугуй засварын үйлчилгээ	Авто машин засварын үйлчилгээ	Гагнуур сантехникийн үйлчилгээ	Нийт дүн
1	Шар-Ус 1-р баг	1	1	-	1	2	3	-	1	<b>9</b>
2	Баянцогт 2-р баг	-	-	1	-	-	1	1	-	<b>3</b>
3	Хонгор овоо 3-р баг	-	-	-	-	-	-	-	-	<b>0</b>
<b>Нийт дүн</b>		<b>1</b>	<b>1</b>	<b>1</b>	<b>1</b>	<b>2</b>	<b>4</b>	<b>1</b>	<b>1</b>	<b>12</b>

### Хоёр. Хөтөлбөрийг боловсруулах үндэслэл, шаардлага

Цаашид гэр ахуйн цахилгаан хэрэгслийн засвар үйлчилгээ, хими цэвэрлэгээ, машин угаалга, гэрэл зургийн үйлчилгээ, гутал засварын үйлчилгээ гэх мэт цэгүүдийг шинээр байгуулах шаардлагатай байна.

Дээрх байдлаас үзэхэд ахуйн үйлчилгээний хүртээмж сумын хэмжээнд харилцан адилгүй байгаа нь харагдаж байна. Суманд үйл ажиллагаа явуулах байр байгаа боловч, ахуй үйлчилгээ эрхлэх дадлага туршлага хангалтгүй байна.

Иймд Сэлэнгэ аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 90 дүгээр тогтоолоор батлагдсан “Ахуй үйлчилгээний салбарыг хөгжүүлэх аймгийн дэд хөтөлбөр”, Сумын Засаг Даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.4.15 дэх заалтын хэрэгжилтийг хангах, сумын хэмжээнд хэрэгжүүлэх, түүнчлэн сумын ахуй үйлчилгээний салбарын өнөөгийн байдалд үнэлэлт дүгнэлт өгч, үйлчилгээний нэр төрөл, чанар хүртээмжийг нэмэгдүүлэн энэ салбарт ажиллагсдын мэдлэг, ур чадварыг сайжруулах болон цаашид баримтлах бодлого, зорилтыг тодорхойлох, удирдлага арга зүйгээр хангах, иргэдээс гарч буй

саналыг харгалзан тэдэнд тулгамдаж буй зайлшгүй хэрэгцээ шаардлагыг үндэслэн энэхүү хөтөлбөрийг боловсруулав.

### **Гурав. Хөтөлбөрийн зорилго, зорилт**

3.1. “Ахуй үйлчилгээний салбарыг хөгжүүлэх сумын дэд хөтөлбөр”-ийг орон нутагт хэрэгжүүлэх, иргэдийн таатай амьдрах боломжийг бүрдүүлэхэд шаардлагатай ахуйн үйлчилгээний цогцолбор төвийн тоог нэмэгдүүлэн үйлчилгээг ойртуулах, өрхийн бичил ахуй үйлчилгээ эрхлэгчдийг албажуулах, ажилгүйдлийг бууруулахад хөтөлбөрийн зорилго оршино.

#### **3.2. Энэхүү зорилгыг дараах зорилтоор хэрэгжүүлнэ:**

3.2.1. Улсын төсвийн болон төр, хувийн хэвшлийн түншлэлийн хөрөнгө оруулалтыг түшиглэн ахуй үйлчилгээний салбарыг хөгжүүлэх

3.2.2. Өрхийн бичил ахуй үйлчилгээ эрхлэгч иргэдийн санал, санаачилгыг дэмжих, урамшуулах;

3.2.3. Салбарын хүний нөөцийн хөгжлийг дэмжих, мэдлэг, ур чадварыг дээшүүлэх арга хэмжээг зохион байгуулж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх

3.2.4. Ахуй үйлчилгээний нэр төрөл, хүртээмжийг нэмэгдүүлэх

### **Дөрөв. Хөтөлбөрийн хамрах хүрээ**

4.1. Сумын Ахуйн үйлчилгээ эрхлэгч болон эрхлэхийг хүсч байгаа иргэд, аж ахуйн нэгжүүд.

### **Тав. Хөтөлбөр хэрэгжих хугацаа**

5.1. Хөтөлбөрийг 2017-2020 онд хэрэгжүүлнэ.

### **Зургаа. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээ**

6.1. Улсын төсвийн болон төр, хувийн хэвшлийн түншлэлийн хөрөнгө оруулалтыг түшиглэн ахуй үйлчилгээний салбарыг хөгжүүлэх зорилтын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

6.1.1. Улсын болон орон нутгийн төсөв, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг ашиглан ахуйн үйлчилгээний салбарыг байгуулах, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх,

6.1.2. Ахуй үйлчилгээний салбарт шинээр ажлын байр бий болгосон ажил олгогчдод дэмжлэг, урамшуулалт олгох,

6.1.3. Явуулын ахуйн үйлчилгээний хэлбэрийг бүх талаар дэмжих.

6.2. Өрхийн бичил ахуй үйлчилгээ эрхлэгч иргэдийн санал, санаачилгыг дэмжих зорилтын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

6.2.1. Ахуй үйлчилгээ эрхлэн ашиг орлогоо нэмэгдүүлэх нөхцөл боломжийг бүрдүүлэх,

6.2.2 Тоног төхөөрөмжийн түрээсийн үйлчилгээ /лизинг/ -нд хамруулахад дэмжлэг үзүүлэх,

6.2.3 Хөнгөлөлттэй зээл, хандив, тусламжинд хамруулахад дэмжлэг үзүүлэх.

6.3. Салбарын хүний нөөцийн хөгжлийг дэмжих, мэдлэг ур чадварыг дээшлүүлэх арга хэмжээг зохион байгуулж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

6.3.1. Ахуйн үйлчилгээний салбарт ажиллагсдыг мэргэжлийн ур чадвар дээшлүүлэх сургалтад хамруулах;

6.3.2. Ахуйн үйлчилгээ эрхлэгчдийг бизнес, менежментийн сургалтад хамруулах;

6.3.3. Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвд нарийн мэргэжлийн ажилчин сургаж бэлтгэх, залгамж чанарыг хадгалах.

#### **6.4 Ахуй үйлчилгээний нэр төрлийг олшируулах зорилтын хүрээнд:**

6.4.1. Сумын төв болон Рашиант тосгоны ахуй үйлчилгээний төвүүдэд дутагдалтай байгаа 2-3 шинэ нэр төрлийн үйлчилгээ бий болгох

6.4.2. Орон нутгийнхаа онцлог, газар зүйн байрлал, хүн амын тоо, дэд бүтцийн хөгжил, иргэдийн эрэлт хэрэгцээ зэргээс шалтгаалж ахуй үйлчилгээний нэр төрөл, хүртээмжийг нэмэгдүүлэх.

### **Долоо. Хөтөлбөрийн санхүүжилт, удирдлага зохион байгуулалт**

#### **7.1. Санхүүжилтийн эх үүсвэр:**

7.1.1. Орон нутаг хөгжлийн сан.

7.1.2. Сум хөгжүүлэх сан;

7.1.3. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан;

7.1.4. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан;

7.1.5. Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт

#### **7.2. Удирдлага зохион байгуулалт:**

7.2.1. Сумын Засаг дарга болон Тамгын газрын дарга хөтөлбөрийн хэрэгжилтэнд хяналт тавьж, нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангаж ажилана;

7.2.2. Сумын Хөдөлмөр эрхлэлт хариуцсан мэргэжилтэн хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргаж, жил бүр Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнана.

### **Найм. Хөтөлбөрийн үр дүн:**

#### **8.1. 2017 онд:**

- Ахуй үйлчилгээний нэр төрөл 20-30%-иар нэмэгдсэн байна.
- Ахуйн үйлчилгээ эрхлэгчдийн ур чадвар, үйлчилгээний стандарт дээшилсэн байна.
- Иргэдийн сэтгэл ханамж нэмэгдсэн байна.
- Сумын нийгэм, эдийн засгийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт 100% хэрэгжсэн байна.

#### **8.2. 2018 онд:**

- Ахуй үйлчилгээний нэр төрлийн өсөлт тогтмолжсон байна.
- Ахуйн үйлчилгээний салбар дахь ажлын шинэ байр 10%-иар нэмэгдсэн байна.
- Өрхийн бичил ахуй үйлчилгээ эрхлэгч иргэд зохистой хөдөлмөр эрхлэлтэнд шилжсэн иргэдийн тоо 10%-иар нэмэгдсэн байна.
- Ахуйн үйлчилгээ эрхлэгчдийн ур чадвар, үйлчилгээний стандарт дээшилсэн байна.

#### **8.3. 2019 онд:**

- Орон нутаг дахь ахуйн үйлчилгээний нэр төрлийн өсөлт тогтмолжсон байна.
- Ахуйн үйлчилгээний салбар дахь ажлын байр тогтмолжсон байна.

- Өрхийн бичил ахуй үйлчилгээ эрхлэгч иргэд зохистой хөдөлмөр эрхлэлтэнд шилжсэн иргэдийн өсөлт тогтмолжсон байна.

8.4. 2020 онд:

- Ахуй үйлчилгээ эрхлэгчдийн тоо 80-100%-иар нэмэгдсэн байна.
- Ахуйн үйлчилгээ эрхлэгчдийн ур чадвар, үйлчилгээний стандарт 100% дээшилсэн байна.
- Сумын нийт өрхийн бичил ахуй үйлчилгээ эрхлэгч иргэд 100% зохистой хөдөлмөр эрхлэлтэнд шилжсэн байна.
- Суманд нэн шаардлагатай байгаа ахуй үйлчилгээний нэр төрөл 100% бий болсон байна.
- Сумын ИТХ-ын 2017-2020 оны стратеги төлөвлөгөөний 4.1.1 болон Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.4.15 дэх заалтууд бүрэн хэрэгжиж биелэлээ олсон байна.

\_\_\_\_\_oOo\_\_\_\_\_